



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН



ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

ӨМНӨХ АУДИТААР ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ
АЖИЛЛААГҮЙГЭЭС ЗӨРЧИЛ ДАВТАГДСААР БАЙНА.

Даланзадгад 2019



Аудитыг гүйцэтгэсэн:

Өмнөговь аймаг дахь
Төрийн аудитын
газрын дарга бөгөөд
тэргүүлэх аудитор

П.Алтанзаяа

Хэлтсийн дарга бөгөөд
аудитын менежер

Ж.Болормаа

Ахлах аудитор:

Т.Хонгорзул

Аудитор:

Г.Шижирболд

Д.Сүрэнжаргал
Д.Заяасүрэн
С.Одончимэг
П.Батцэцэг
Б.Номинцэцэг
Ч.Наранбадрах

2019 оны 4 дүгээр сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70533539, 70533552
дугаарын утсаар харилцана
уу.

Тайланг ӨМТАГ-ын
www.umnugovi@audit.gov.mn
цахим хуудаснаас үзнэ үү.

Хаяг: Нутгийн удирдлагын
ордон, 3 давхар, 303 тоот

Агуулга

Хуудас

Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгт, график, дүрслэл, бүдүүвчийн жагсаалт	4
Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	5-7
Бүлэг 1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөр, нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байна.	4-5
Бүлэг 2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.	6
Бүлэг 3. Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний үр ашгийг сайжруулах шаардлагатай байна.	7-8
Дүгнэлт	9
Зөвлөмж	10
Холбогдох байгууллагын санал	11
Аудитаар илэрсэн зөрчлийн хуудас	12
Тэргүүлэх аудиторовын тушаал	



ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ЗГ	Засгийн газар
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ТАХ	Төсөл арга хэмжээ
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
БОЭТ	Бүсийн оношлогоо эмчилгээний төв



Хүснэгт, графикийн жагсаалт

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн судалгаа	7
Хүснэгт 2	Сумдын хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн судалгаа	7
Хүснэгт 3	Хийгдсэн хөрөнгө оруулалтын ангиллалын судалгаа	10



Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын Орлогчийн “Үндэсний аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 2019 оны А/03 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Орон нутгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн байна уу?
- Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнтэй байна уу?
- Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ үр нөлөөтэй, үр ашигтай байна уу?

Хамрах хүрээ:

Аудитаар орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрх бүхий байгууллагуудын хүрээнд шалгав.

Аудитын дэд зорилт, асуудлын шинжилгээнд тусгагдаагүй бусад чиглэлээр болон бүрэн хэмжээгээр үйл ажиллагааг үнэлж, дүгнэх зорилго агуулаагүй болно.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд ТХШС, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100)-ийг ашиглах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, байгууллагын худалдан авалт хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын урьдчилсан судалгааны явцад хэрэгжүүлсэн горим, дүн шинжилгээ, ярилцлагын явцад тодорхойлогдсон эрсдлийн үнэлгээнд өөрчлөлт ороогүй болно.



**Аудитад
ашигласан
шалгуур:**

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур болгон авч үзлээ.

- Төсвийн тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”

**Аудит
хийсэн
багийн
бүрэлдэхүүн**

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор П.Алтанзаяа хянан удирдаж, аудитын менежер Ж.Болормаа үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Т.Хонгорзул, Г.Шижирболд, аудитор Д.Сүрэнжаргал, Д.Заяасүрэн, С.Одончимэг, П.Батцэцэг, Б.Номинцэцэг, Ч.Наранбадрах нар гүйцэтгэв.

**Аудитын
хугацаа**

Аудитын 2019 оны 02 дугаар сарын 26-нд эхэлж, 4 дүгээр сарын 25-нд хүртэл хугацаанд хийж гүйцэтгэв.



Аудитын дүн

БҮЛЭГ 1

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөр, нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байна.



Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ийн өдрийн 5/4 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 62 ТАХ –нд 34,809.5 сая төгрөг, 22 хөтөлбөрт 4,836.9 сая төгрөг, байгаль хамгаалах чиглэлээр 12 төсөл арга хэмжээнд 8,116.9 сая төгрөг зарцуулахаар баталсан байна. Энэ нь Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байна.

АЗДГазар нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2018 оны төлөвлөгөөг боловсруулахтай холбогдуулан Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.4 ¹дэх заалтын дагуу холбогдох байгууллагуудаас санал авч боловсруулалт хийж эрэмбэлсэн байна.

Хүснэгт 1. Аймгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт (сая төгрөг)

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөл арга хэмжээний тоо	Мөнгөн Дүн
1	Хөрөнгө оруулалт ТАХ	62	34,809.5
2	Төсөл хөтөлбөр	22	4,836.9
3	Байгаль хамгаалах чиглэл	12	8,116.9
	Нийт	96	47,763.4

Сумдын хувьд төсвийн хөрөнгөөр 2018 онд 110 ТАХ-нд 2,228.8 сая төгрөг зарцуулахаар сумын ИТХ-аар батлуулж ажилласан байна.

Хүснэгт 2. Сумын хөрөнгө оруулалтын төлөвлөлт (сая төгрөг)

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөл арга хэмжээний тоо	Мөнгөн Дүн
1	Баяндалай	0	0
2	Баян-Овоо	0	0
3	Булган	2	40.0
4	Гурвантэс	18	816.7
5	Мандал-Овоо	2	37.9
6	Манлай	11	263.0

¹ Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах



7	Ноён	4	11.6
8	Номгон	2	52.8
9	Сэврэй	0	0
10	Ханбогд	19	295.7
11	Ханхонгор	5	26.8
12	Хүрмэн	8	47.0
13	Цогт-Овоо	0	0
14	Цогтцэций	39	637.2
15	Даланзадгад	0	0
Нийт		110	2,228.8

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтуудын зураг төсөв, магадлал хийлгэх ажлыг төсвийн ерөнхийлөн захирагч буюу захиалагч бүрэн хариуцана гэсэн дагуу 2018 оны төсөв батлагдахаас өмнө төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын зураг төсөв, тоног төхөөрөмж, их засварын ажлуудын төсөвт өртгийг тооцоолж хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан байна.

Гэвч зарим хөрөнгө оруулалтын тооцоо судалгаа хангалтгүй хийгдсэнээс зураг төсөвт нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Үүнд:

- Булган сумын төвийн төвлөрсөн цэвэр, бохир усны шугамыг барих ажил
- Мандал-овоо сумын нийтийн эзэмшлийн ногоон байгууламж байгуулах ажил
- Төрийн байгууллагын засвар үйлчилгээ тохижилтын ажил зэрэг ажлууд байна.

Аймаг болон сумдын хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгагдсан 384.6 сая төгрөгийн төсөл арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24², Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2³ дахь заалтай тус тус нийцэхгүй. Тухайлбал:

- Сэврэй сумын ИТХ-ын ажлын албаны автомашины засвар
- Ханбогд сумын ЗДТГ-ын автомашины засвар,
- Татварын хэлтсийн автомашины засвар,
- Эрүүл мэндийн газрын автомашины засвар сэлбэг хэрэгсэл,
- БОЭТ-ийн яаралтай түргэн тусламжийн бэлэн байдлыг хангах,
- Цогтцэций сум- говь шанхын дууг зааж сургах, худалдан авах ажиллагааны сургалтанд хамруулах, малчдыг гадаад дотоод сургалтанд хамрагдах,
- Ханбогд сум- нутгийн зөвлөлийн болон оюутан залуучуудын чуулга уулзалт зохион байгуулах, сум дундын эмнэлэгийн эмний өрийг шийдвэрлэх, Хайрхан багийн эрүүл мэндийн үйлчилгээний зардал,
- Манлай сум- сумын төвийн ундны усны худаг засварлах,
- Ханхонгор сум- Авто машины засвар үйлчилгээ зэрэг зардлууд байна.

² Хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлэх тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг

³ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна.....



Цаашид орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын жагсаалтыг батлуулахдаа тооцоо судалгаа бүрэн хийгдсэн хөрөнгө оруулалтын шинж чанартай төсөл арга хэмжээг хэрэгжүүлэн Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон бусад хууль тогтоомжид нийцүүлж байх тухай албан шаардлагыг Аймгийн засаг даргад хүргүүлж ажиллалаа.

БҮЛЭГ 2 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.



ТБОНӨХБАҮХАТ хууль болон ЗГ-ын 2013 оны 68 тоот тогтоолоор батлагдсан *“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”* журмын дагуу босго үнийн нөхцлийг хангасан 67 төсөл арга хэмжээнд нээлттэй тендер, 29 төсөл арга хэмжээнд харьцуулалтын аргаар 12 төсөл арга хэмжээнд зөвлөх үйлчилгээний тендер шалгаруулалт зохион байгуулжээ.

Тендер шалгаруулалтад үнэлгээний хороо гишүүдийн ирцийн бүрдлээс хамааран нээлттэй тендер шалгаруулалтыг 30 хоног, харьцуулалтын тендер шалгаруулалтыг урилга илгээсэн өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй хоногоор тогтоон, үнэлгээ хийж дүгнэлтийг захиалагчид хүргүүлэн ТБОНӨХБАҮХАТ хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 -д заасан дагуу тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулсан байна.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45 дугаар зүйлийн 45.6⁴-д заасны дагуу 2,952.9 сая төгрөгийн 124 ТАХ-н сумдад эрх шилжүүлэн гүйцэтгүүлсэн байна.

Тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанаас үүссэн хэмнэлтээс 503.2 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан байна. Тухайлбал:

- Төрийн үйлчилгээний засвар үйлчилгээ, тохижилтыг ажилд 29.9 сая төгрөг,
- Булган сумын төвийн төвлөрсөн цэвэр, бохир усны шугамыг барьж байгуулах ажилд 80.0 сая төгрөг,
- 6-р багийн төвийн барилга угсралтын ажилд 69.8 сая төгрөг,
- 8-р багийн төв, өрхийн эмнэлгийн барилгын ажилд 79.9 сая төгрөг,
- Ахмадын хээрийн сувилалын гадна талбайн тохижилт, хашаажуулах ажилд 39.9 сая төгрөг
- Мандал-овоо суманд байгуулагдсан нийтийн эзэмшлийн ногоон байгууламж байгуулах ажилд 34.9 сая төгрөгийн ажлуудад нэмэлт гэрээ байгуулсан байна.

⁴ Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь шаардлагатай гэж үзвэл сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт энэ хуулийн 45.2.2-т заасан эрхээ шилжүүлж болно.



Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1⁵, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын 4.22⁶ дэхь заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна. Иймд төсвийг үр ашигтай зарцуулах, худалдан авах ажиллагаанаас үүссэн хэмнэлтийг захиран зарцуулахгүй байх албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлж ажиллалаа.

БҮЛЭГ 3**Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний үр ашгийг сайжруулах шаардлагатай байна.**

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2018 онд хийгдэх хөрөнгө оруулалтыг 47,763.4 сая төгрөгөөр батлаж, гүйцэтгэлээр 34,191.8 сая төгрөгийн санхүүжилт гарсан байна. Үүнээс 1,257.5 сая төгрөгийг худалдан авах ажиллагаа оройтож зарласан, цаг улирлын байдлаас шалтгаалан он дамжин хэрэгжих нөхцөл үүссэн, 2019 оны төсөвт тусгагдаагүй, ирэх онд төсвийн тодотгол хийх нь тодорхойгүй зэрэг шалтгаанаар орон нутгийн барьцаа дансанд байршуулан, хөрөнгө оруулалтын тайлан мэдээнд гүйцэтгэл 100 хувь гарсанаар мэдээлсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 43.6⁷ дах заалттай нийцэхгүй байна.

Тайлант онд хийгдсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг тооцон 257 ТАХ-нд 32,934.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 8.692.8 сая төгрөгөөр өссөн нь 2018 оныг аймгийн хэмжээнд бүтээн байгуулалтын жил болгон зарласантай холбоотой байна. Хийгдсэн хөрөнгө оруулалтыг ангилан харуулбал:

Хүснэгт 3. Хөрөнгө оруулалтын ангилал (сая төгрөг)

№	Үзүүлэлт	Мөнгөн дүн	Хувь
1	Барилга, байгууламж	5,139.5	46.0
2	Зураг төсөв	1,053.2	3.2
3	Их засвар	1,979.2	6.0
4	Автомашин	1,575.7	4.8
5	Тоног төхөөрөмж	2,612.2	7.9
6	Шугам сүлжээ	3,588.9	10.9
7	Нийтийн эзэмшлийн талбай тохижуулах, худаг гаргах	1,410.2	4.3
8	Байгаль хамгаалах чиглэл	5,449.7	16.5
9	Зардал	125.6	0.4
	ДҮН	32,934.2	100.0

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтаас 125.6 сая төгрөг буюу 0.4 хувийг орон нутгийн өмчлөлд хамаарахгүй, урсгал зардал эзэлж

⁵төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

⁶ хөрөнгө оруулалтын ажлын тендер шалгаруулалтын дүнд бий болсон хэмнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч зарцуулах эрхгүй

⁷ Бараа ажил үйлчилгээний чанарын баталгаат хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувь хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг.....



байгаа нь өмнөх аудитаар илэрсэн зөрчил арилахгүй, давтан гарч байгаа нь Төрийн аудитын байгууллагын зөвлөмж, албан шаардлагыг бүрэн биелүүлэхгүй байгааг харуулж байна.

Мөн БОЭТөвд 23.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг гэрээний дагуу 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр акт үйлдэн хүлээн авсан байна. Гэвч гүйцэтгэгч байгууллагад санхүүжилтийг 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн өдөр шилжүүлсэн нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.16⁸ дахь зүйлийг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд аймаг, сумдын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан 32.426,0 сая төгрөгийн 234 ТАХ-г тухайн ашиглагч байгууллага бүртгэлд тусгасан байна. Гэвч зарим байгууллага хөрөнгийг бүртгэж ажиллаагүй байна. Тухайлбал:

- БОЭТ-ийн 50 ортой эмнэлгийн засварын зураг төсөв боловсруулах 19.8 сая төгрөгийн өртөгтэй ажил,
- Даланзадгад сумын гэр хорооллыг камержуулах зураг төсөв боловсруулах 32.2 сая төгрөгийн өртөгтэй ажил,
- Т.Борын талбайн зураг төсөв боловсруулах 20.0 сая төгрөгийн өртөгтэй ажил,
- Мандал-Овоо сумын нийтийн эзэмшлийн ногоон байгууламж бүхий талбай байгуулах 211.2 сая төгрөгийн өртөгтэй ажил,
- Мандал-Овоо сумын цэцэрлэгийн барилгын засварын 65.7 сая төгрөгийн өртөгтэй ажил,
- Эрүүл мэндийн салбарын аппликейшн зураглал, техникийн хүчин чадлыг боловсруулах 4.4 сая төгрөгийн өртөгтэй ажил,
- Хүлэмжийн усалгааны зориулалтаар инженерийн хийцтэй 58.3 сая төгрөгийн өртөгтэй худаг гаргах зэрэг ажлууд байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1⁹, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2¹⁰ дахь заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлуудыг комиссын акт хүлээж авсан өдрөөр тасалбар болгон тухайн ашиглагч байгууллага орон нутгийн өмчид бүртгэхгүй жилийн эцэст буюу 12 сард хөрөнгөд бүртгэж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг буруулах цаашлаад элэгдлийн зардал буруу тооцогдох зэрэг эрсдэлийг үүсгэж байна.

Мөн ажил хүлээлцэх комисс томилохдоо ашиглагч байгууллагаас төлөөлөл оролцуулаагүйгээс уг ТАХ-г бүртгэлд тусгахгүй орхигдуулах байдал түгээмэл

⁸ Захиалагч байгууллага, өөрийн дансанд санхүүжилт орсноос хойш ажлын 3 хоногийн дотор гүйцэтгэгч байгууллагад санхүүжилтийг олгоно. Санхүүжилтийг тогтоосон хугацаанд гүйцэтгэгчид шилжүүлээгүйгээс үүдэн гарах бүх хариуцлагыг захиалагч хариуцлагыг захиалагч хариуцна.

⁹Бүх хөрөнгө хөрөнгө оруулалт авлага

¹⁰ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.



байна. Иймээс захирамж, тушаалын төсөл боловсруулж буй бодлогын мэргэжилтнүүд анхаарч ажиллах шаардлагатай байна.



Аудитын дүгнэлт

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлтэй уялуулан төлөвлөсөн байна.
2. Зарим хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг үндэслэлгүй тооцоо судалгаа хангалтгүй хийсэн байна.
3. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанаас үүссэн хэмнэлтээс 503.2 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан байна.
4. Худалдан авах ажиллагаа оройтож зарласан, цаг улирлын байдлаас шалтгаалан он дамжин хэрэгжих нөхцөл үүссэн, 2019 оны төсөвт тусгагдаагүй, ирэх онд төсвийн тодотгол хийх нь тодорхойгүй зэрэг шалтгаанаар 40 ТАХ буюу 1,257.5 сая төгрөгийг орон нутгийн барьцаа дансанд байршуулсан байна.
5. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтаас 125.6 сая төгрөг буюу 0.4 хувийг орон нутгийн өмчлөлд хамаарахгүй, урсгал зардал эзэлж байна.
6. Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон ажлуудыг хөрөнгийн бүртгэлд шуурхай тусгаж, ашиглалт хамгаалалтыг сайжруулах шаардлагатай байна.



Аудитын зөвлөмж

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймаг, сумдын ИТХ-ын дарга нарт

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтыг батлахдаа Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг хэрэгжүүлэн орон нутгийн өмчлөлд хамаарахгүй, урсгал зардлыг батлахгүй байх.



Холбогдох байгууллагын санал

Аудитаар илэрсэн нийт асуудлын бүртгэлийн маягт

Хавсралт 9

4 дэх түвшингийн асуулт	Аудитаар илэрсэн асуудал зөрчил	4 дэх түвшингийн асуудалд үзүүлэх нөлөө (Материаллаг байдал Их, Дунд, Бага)	Тухайн байгууллагын санал	Аудитын багийн шийдвэр
Хууль журамд заасан шаардлагыг хангасан төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан эсэх	Хөрөнгө оруулалтын жагсаалтад орон нутгийн өмчлөлд хамаарахгүй, улсын төсөвт байгууллагуудын урсгал болон хөрөнгө худалдан авах 384.6 сая төгрөгийн зардлыг тусгасан.	Дунд	АИТХ-ын тогтоолоо батлагдсан төсвийн хүрээнд "Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль"-ийн 30 дугаар зүйлд заасан "Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх"-ийн хүрээнд нутаг дэвсгэртээ батлан хамгаалах, гамшгаас хамгаалах, нийгмийн хэв журам хамгаалах ажлыг удирдах, цэргийн анги, салбар, улсын аюулгүй байдлыг хангах болон хууль хяналтын бусад байгууллагатай харилцан ажиллах, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтыг бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэсэн.	Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах тухай албан шаардлага хүргүүлэх.
	Худалдан авах ажиллагаа оройтож зарласан, цаг улирлын байдлаас шалтгаалан он дамжин хэрэгжих нөхцөл үүссэн, 2019 оны төсөвт тусгагдаагүй, ирэх онд төсвийн тодотгол хийх нь тодорхойгүй зэрэг шалтгаанаар 1,257.5 сая төгрөгийг орон нутгийн барьцаа дансанд байршуулсан.	Дунд	2018 оны 386 дугаар тогтоолоор Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын гарч хэрэгжилтийг зохион байгуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосон. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т заасны дагуу төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан төсвийн хүрээнд зохицуулалт хийсэн.	ТБОНӨХБАХХАТХ-ийн 43.6 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах тухай албан шаардлага хүргүүлэх.



Аудитаар илэрсэн нийт асуудлын бүртгэлийн маягт

Аудитаар илэрсэн нийт асуудлын бүртгэлийн маягт	Хавсралт 9
Тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанаас үүссэн хэмнэлтээс 503.2 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу нэмэлт гэрээ байгуулсан. 2018 онд зайлшгүй нэмэлт гэрээ байгуулсан ажлуудад дараах тайлбарыг хүргүүлж байна. -2018.07.09-ний өдрийн 16/03/32/231 дугаар бүхий Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн "Дутагдал арилгуулах тухай" албан шаардлага ирүүлсний дагуу ажлын зургийн зөрчлийг арилгаж, нэмэлт ажлыг гүйцэтгүүлсэн. /Д3 сумын 6-р багийн төвийн барилга 69,8 сая төг/ -2018.07.09-ний өдрийн 16/03/32/231 дугаар бүхий Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн "Дутагдал арилгуулах тухай" албан шаардлага ирүүлсний дагуу ажлын зургийн зөрчлийг арилгаж, нэмэлт ажлыг гүйцэтгүүлсэн. /Д3 сумын 8-р багийн төвийн барилга 79,9 сая төг/ -Засварын ажлын төсөвт дутуу тусгагдсан 12,3 м2 плитан шал, 14,3 м2 паркетан шал, 14 цонхыг шинээр солих, 329,12 м2 гадна парпедыг шавардах ажлыг нэмэлтээр гүйцэтгүүлсэн. Эдгээр ажлыг хийж байж барилгыг ашиглалтад оруулахаар зайлшгүй нөхцөл байдал үүссэн. /Цогт-овоо сумын ЗДТГ-ын барилгын засвар 18,9 сая төг/ -Ахмадын хээрийн сувиллын барилгын ажилд тусгагдаагүй буюу гадна тохижилт, хашаажуулалтыг ажлыг Говийн Оюу сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэн хэрэгжүүлсэн. /39,9 сая төг/ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын 4.22 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллах тухай албан шаардлага хүргүүлэх.

Дунд



Аудитаар илэрсэн нийт асуудлын бүртгэлийн маягт

БООТөвд 23.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг гэрээний дагуу 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр акт үйлдэн хүлээн авсан байна. Гэвч гүйцэтгэгч байгууллагад санхүүжилтийг 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр шилжүүлсэн.

Дунд

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан –"Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-д зааснаар санхүүжилтийн материал иж бүрдэл дутуу, шаардлага хангахгүй тохиолдолд санхүүжилт олгохгүй буцаах, холбогдох материалын бүрдлийг хангасны тохиолдолд санхүүжилтийг олгох боломжтой.

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан –"Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам"-ын 4.16 дахь заалтын хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

Хавсралт 9

Бүртгэл хөтөлсөн: Багийн ахлах

Багийн гишүүн

Т.Хонгорзул

Д.Сүрэнжаргал

П.Батцэцэг

Ж.Болормаа

П.Алтанзаяа

Н.Наранбаатар

Ө.Баянмөнх

Ж.Сүх-эрдэнэ

С.Уранчимэг

Ё.Номинтунгаалаг

Бүртгэлтэй танилцаж хянасан: Аудитын менежер

Дарга, Тэргүүлэх аудитор

Бүртгэлтэй танилцаж зөвшөөрсөн: Засаг дарга

АЗДТГазар

ХОХБТХ-ийн дарга

Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

СТСХ-ийн мэргэжилтэн



Аудитаар илэрсэн зөрчлийн хуудас

Орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүнд хийсэн аудитын зөрчлийн нэгтгэл									
№	Аудитын чиглэл	Зөрчсөн хуулийн зүйл заалт	Алдаа зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая.төг/	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан байгууллага, албан тушаалтны	
					Нэр	Огноо	Байгууллагын нэр	Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4.0	5	6		8	9
Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар									
1	Орон нутгийн төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөлийг хууль тогтоомжид нийцүүлэн үндэслэлтэй боловсруулж батлуулсан уу?	Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт	Хөрөнгө оруулалтын жагсаалтад орон нутгийн өмчлөлд хамаарахгүй, улсын төсөвт байгууллагуудын урсгал болон хөрөнгө худалдан авах 125.6 сая төгрөгийн зардлыг тусгасан.	125.6	Албан шаардлага	2019.04.25	АЗДТГ	Засаг дарга	Н.Наранбаатар
2			Сумдад хийгдсэн хөрөнгө оруулалтын жагсаалтад орон нутгийн өмчлөлд хамаарахгүй, урсгал болон хөрөнгө худалдан авах 257.4 сая төгрөг баталж зарцуулсан.	257.4	Зөвлөмж	2019.04.25	Аймаг, сумдын ИТХ	Аймаг, сумдын ИТХ-ын дарга нарт	Аймгийн ИТХ-ын дарга Х.Сүпир, сумдын ИТХ-ын дарга нарт
3	Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг хууль тогтоомжид заасны дагуу гүйцэтгэж тайлагнасан уу?	ТБОНХБХУХАТХ-ийн 43.6 дахь заалт	Худалдан авах ажиллагаа оройгож зарласан, цаг улирлын байдлаас шалтгаалан он дамжин хэрэгжих нөхцөл үүссэн, 2019 оны төсөвт тусгагдаагүй, ирэх онд төсвийн тодотгол хийх нь тодорхойгүй зэрэг шалтгаанаар 1,257.5 сая төгрөгийг орон нутгийн барьцаа дансанд байршуулсан.	1,257.5	Албан шаардлага	2019.04.25	АЗДТГ	Засаг дарга	Н.Наранбаатар
4		Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалын 4.22 дахь заалт	Тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанаас үүссэн хэмнэлтээс 503.2 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан.	503.2	Албан шаардлага	2019.04.26	АЗДТГ	Засаг дарга	Н.Наранбаатар
Нийт дүн				2,143.7					



Тайлан баталгаажуулах тушаал



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/10

Даланзадгад

“Аудитын тайлан баталгаажуулах тухай”

“Төрийн аудитын тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/92 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.40 дэх заалт, мөн 2003 оны 53 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2, мөн 2017 оны А/188 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг нийслэл дахь төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх”-ийн 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, тус аудитаар өгсөн албан шаардлагын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Аудитын тайланг аймгийн Засаг дарга /Н.Наранбаатар/-д хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2020 оны 1 дүгээр улиралд Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг даргад зөвлөсүгэй.
4. Албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер /Ж.Болормаа/-д даалгасугай.
5. Аудиттай холбоотой ажлын болон нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивийн нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд түгээхийг гүйцэтгэлийн аудитын баг /Т.Хонгорзул/-т үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  П.АЛТАНЗАЯА



D:Bichig hereg/Tushaal-A4